

Өвөр Монголын өөртөө засах орны Малжих хошууны үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлтийн шинжилгээ

Тангудайн Бүрэнжаргал¹, Баюужин Хорвоо^{1*}, Сундуйн Бадарч²

¹ Угсаатан зүй, нийгэм судлалын сургууль, Өвөр Монголын их сургууль, Их сургуулийн гудам 235, Хөххот, ӨМӨЗО, БНХАУ

² Эдийн засаг, бизнесийн сургууль, ХААИС, Зайсан 17024, Улаанбаатар, Монгол Улс

*Холбоо баригч зохиогч: 22113006@mail.imu.edu.cn

Хүлээн авсан: 01.10.2021

Хянасан: 08.11.2021

Хэвлэлтэд орсон: 31.12.2021

Хураангуй

Уг судалгааны ажлаар саарал хамаарлын шинжилгээний арга ашиглан Жарууд хошууны үйлдвэрлэлийн бүтэц болон эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарлын эмпирик судалгааг хийлээ. Хилийн бүс, угсаатны нутаг, экологийн эмзэг бүс, эдийн засгийн хөгжил хоцронгуй нутаг болох Хятадын хойд нутгийн малжих орны түүхийн өөрчлөлтийн явцад бий болсон үйлдвэрлэлийн бүтцийн үе шатат нөлөөллийг судлахын зэрэгцээ хөгжлийн ерөнхий нөхцөлийг системтэйгээр нэгтгэн дүгнэж, дүн шинжилгээ хийсэн юм. Эмпирик судалгааны үр дүнд тулгуурлан Жарууд хошуу нь үйлдвэрлэлийн бүтцийг сайжруулж, орчин үеийн үйлдвэрлэлийн системийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийн төвшинг нэмэгдүүлж, аж үйлдвэрлэлийн паркийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, үйлдвэрлэлийн гинжин хэлхээг хөгжүүлэхэд анхаарч бүтээгдэхүүний чанарыг сайжруулах хэрэгтэй зэрэг саналыг дэвшүүллээ.

Түлхүүр үг: Малжих хошуу нутаг, үйлдвэрлэлийн бүтцийн хувирлын явц, Жарууд хошуу

Оршил

Хятад улсын эдийн засаг хурдтай хөгжлийн үе шатруу шилжсэн өнөө үед аж үйлдвэрлэлийн бүтцийг оновчтой болгох, сайжруулах асуудал нь хятад улсын орчин үеийн бүтээн байгуулалтын ерөнхий үйл явцтай холбоотой юм. Жарууд хошуу нь ӨМӨЗО-ы 33 малжих хошууны нэг бөгөөд уг судалгааны үр дүн нь мал аж ахуйн бүс нутгийг хөгжүүлэхэд тодорхой ач

холбогдолтой юм. Аж үйлдвэрийн бүтцийн хувьслын зүй тогтол нь тухайн улсын эдийн засгийн хэлбэлзэлд шууд нөлөөлдөг болохыг дотоод болон гадаадын судалгааны үр дүнгээс харж болно. Аж үйлдвэрийн бүтцийн оновчлолыг хурдасгах нь эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах чухал хэрэгсэл юм.

Материал, арга зүй

Сүүлийн үеийн судалгаанд аж үйлдвэрийн бүтцийн оновчтой байдлыг шинжлэхийн тулд саарал корреляцийн шинжилгээний аргыг ашиглаж эхэлсэн ба В.Петтигийн дэвшүүлсэн Петти-Кларк теоремын дагуу аж үйлдвэрийн бүтцийн хөгжил нь эдийн засгийн хөгжилтэй нийцэж байгаа эсэхийг дүгнэж байна.

Саарал корреляцийн загвар нь аж үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлтийн үр дүнд бий болох эдийн засгийн үр нөлөөг тайлбарлаж чаддаг. Иймд энэхүү судалгаанд Жарууд хошууны үйлдвэрлэлийн бүтцэд гарсан өөрчлөлтийг өмнөх судалгаануудад тулгуурлан системтэйгээр дүн шинжилгээ хийхээр зорьсон болно.

Судалгааны үр дүн

Жарууд хошууны үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлтийн шинжилгээ

Шинэ Хятад улс байгуулагдсанаас хойш Жарууд хошуу нь байгалийн баялаг, нөхцөлөө ашиглан хөдөө аж ахуйн(ХАА) үйлдвэрлэлийн хөгжлийг

ихээхэн дэмжиж, ХАА-н үйлдвэрлэлийн үндэс суурийг бэхжүүлсэн юм. Жарууд хошууны Ардын засгийн газар ХАА-н үйлдвэрлэлийн хөгжлийг ямагт эн тэргүүнд тавих ажлын чиглэлийг хүлээн авсан нь тус хошууны ХАА-н үйлдвэрлэлийн эдийн засгийн үйлдвэржилтийн хөгжлийг ахиулж, эдийн засгийн үр нөлөөг сайжруулсан юм. Жарууд хошуу нь ХАА-н үйлдвэрлэлийг 1960, 1970-аад оныг хүртэл хөгжүүлсэн ба энэ үеэс хоёрдогч үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлсэн нь хүнсний боловсруулах үйлдвэрлэл, засвар, барилгын материал боловсруулах үйлдвэрлэл, хэвлэх үйлдвэрлэл, нүүрс олборлох үйлдвэрлэлд суурилсан аж үйлдвэрийн хөгжлийн системийг аажмаар бий болгосон байна.

1980-аад оноос аж үйлдвэржсэн эдийн засгийн хөгжлийг бүх талаар дэмжиж, үйлдвэрлэлийн оновчлолыг бий болгож, нүүрс, бал чулууны олборлолт давамгайлсан эрчим хүчний үйлдвэрлэл, зэс, цайр, хар тугалганы олборлолт давамгайлсан өнгөт металлын үйлдвэрлэл, үр тарианы тос, хонь, үхрийн мах, ноолуурын анхан шатны боловсруулалт давамгайлсан ХАА-н бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл, хөнгөн гангийн үйлдвэрлэл, цемент, чулуунцар нунтаглах чиглэл давамгайлсан барилгын материалын үйлдвэрлэл зэрэг үйлдвэрлэлийн хөгжлийн бүтэц бүрэлдэж, үйлдвэрлэлийн паркийн бүтээн байгуулалтыг тасралтгүй эрчимжүүлж, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн аж үйлдвэрлэлийн кластер аажим бүрэлдсэн байна.




Figure 1. The changing trend of the primary industry structure in Zaruud Banner from 1949 to 1988

1-р зургаас харахад 1949-1988 онд Жарууд хошууны анхдагч үйлдвэрлэлд салбар бүрийн үйлдвэрлэлийн хэмжээ хөрөөний ир хэлбэрийн өсөлттэй, газар тариалан (ГТ), мал аж ахуй (МАА)-н үйлдвэрлэлийн эзлэх хувь харьцангуй өндөр байв. 1949-1965 онд ГТ-ийн үйлдвэрлэл нь анхдагч үйлдвэрлэлийн хөгжлийн гол цөм нь болж, бусад үйлдвэрлэлээс илүү их өртгийг бий болгож байсан бол 1967 оноос эхлэн МАА-н үйлдвэрлэл эрчимжиж, ГТ-ийн үйлдвэрлэлийг аажмаар орлон анхдагч үйлдвэрлэлийн гол салбар болов. Энэ төлөв 1983 оныг хүртэл үргэлжилсэн ба энэ үеэс МАА-н үйлдвэрлэл

буурах хандлагатай болж, ГТ болон бусад салбарын үйлдвэрлэл аажим өсжээ. 1949 онд Жарууд хошууны үр тариа, буурцгийн нийт үйлдвэрлэл 18.788 сая.кг байсан бол 1986 онд 95.979 сая.кг-д хүрч үйлдвэрлэлийн хэмжээ 5 дахин өссөн байна. 1986 онд хошууны нийт тариалангийн талбай 997400га, газар тариалангийн нийт үйлдвэрлэл 44.14 сая юаньд хүрсэн нь 1949 оноос 4.8 дахин нэмэгджээ. 1949 онд Жарууд хошууны нийт мал сүрэг 49300 толгой байсан бол 1986 онд 936300 толгой болж 19 дахин өссөн байна




Figure 2. The development trend of the proportion of output value structure of the three major industries in Zaruud Banner from 1989 to 2018

1989-2018 онд Жарууд хошууны үндсэн 3 үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин ихээхэн хэлбэлзэлтэй байна. Зураг 2-оос харахад, үйлдвэрлэлийн бүтэц эхэн үедээ буюу 1989 онд үндсэн 3 үйлдвэрлэлийн бүтцийн харьцаа 72.9:8.6:18.5 ба “1,3,2” гэсэн хөгжлийн чиг хандлагатай байсан бол 2004 оноос 36.8:2.4:40.8 болж “3,1,2” гэсэн хэлбэрт шилжжээ. 2007 оноос 27.5:37.1:35.4 болж “2,3,1” хэлбэрт шилжиж эхэлсэн ба 2017 оныг хүртэл үргэлжилсэн байна. 2018 онд үндсэн 3 үйлдвэрлэлийн бүтцийн харьцаа 25.7:34.7:39.6 болж үйлдвэрлэлийн бүтэц “3,2,1” хэлбэрт шилжжээ. 30 жилийн хөгжлийн явцад анхдагч

үйлдвэрлэлийн хувийн жин тасралтгүй буурсан ч 2016 оноос бууралтын хэмжээ саарсан байна. Харин хоёрдогч үйлдвэрлэлийн хувийн жин 2005 оныг хүртэл аажим өсөлттэй байж 2005 онд ялимгүй буурсан ч эргээд хурдтай өссөөр 2008 оноос үндсэн 3 үйлдвэрлэлийн хамгийн их хувийг эзэлж, 2013 оноос эхлэн аажим буурсан байна. Гуравдагч үйлдвэрлэлийн хувийн жин тодорхой хугацаанд тогтмол өсөлттэй байж, 2005 онд өсөлтийн хамгийн өндөр төвшиндээ хүрсэн ба үүнээс хойш аажим буурчээ. 2013 оноос эргэн өсөж, 2018 онд хувийн жин хамгийн өндөр үйлдвэрлэл болсон байна.

Жарууд хошууны үйлдвэрлэлийн бүтэц болон эдийн засгийн өсөлтийн хамаарлын шинжилгээ

Саарал хамаарлын шинжилгээний арга

Саарал хамаарлын шинжилгээний арга нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж буй янз бүрийн тоон цувааны хоорондын хамаарлын төвшинг шинжлэх боломжтой учир стандарт өгөгдлийн цуваа болон харьцангуй өгөгдлийн цувааг байгуулах замаар хамаарлын төвшинг тооцох ба үүний үндсэнд стандарт болон стандартчилагдсан хугацааны цувааны хоорондын хамаарлын нягтыг тооцоолдог.

Саарал хамаарлын шинжилгээнд хамаарлын утга их байх тусам судалж буй хүчин зүйлсийн хоорондын хамаарал илүү нягт байна. Иймд үйлдвэрлэлийн өөрчлөлтийн хүчин зүйл болон эдийн засгийн хөгжлийн хүчин зүйлийг тогтоох замаар эдийн засгийн нөлөөллийн шинжилгээ хийж, үйлдвэрлэлийн өөр өөр бүтэц, цаг хугацааны өөр өөр төвшинд эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөөлж буйг судалсан. Саарал хамаарлын шинжилгээний загвар нь зүй

тогтлын өөрчлөлтийн нөлөөллийг тусгадаггүй бөгөөд шинжилгээний үр дүнгийн тоон болон чанарын шинжилгээ нь хоорондоо зөрчилддөггүйгээрээ бусад статистикийн загвараас давуу талтай юм. Ли Шиаоли (2014) болон Ли Хуймин (2015) нар үйлдвэрлэлийн бүтэц, эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарлыг шинжлэхдээ үндсэн 3 үйлдвэрлэлийн хэмжээг харьцангуй өгөгдлийн цуваагаар, тухайн хугацаанд харгалзах ДНБ-ний хэмжээг стандарт өгөгдлийн цуваагаар авч, саарал хамаарлын шинжилгээг ашиглан хугацааны өөр өөр үе дэх үндсэн 3 үйлдвэрлэлийн эдийн засгийн хөгжлийн төвшинг үнэлсэн байдаг. Иймд уг судалгааны ажлаар Жарууд хошууны үндсэн 3 үйлдвэрлэлийн хөгжлийн төвшин (үйлдвэрлэлийн хэмжээ)-г харьцангуй өгөгдлийн цуваагаар, эдийн засгийн ерөнхий хөгжлийн төвшин (ДНБ)-г стандарт өгөгдлийн цуваагаар авч саарал хамаарлын шинжилгээ хийсэн ба үндсэн 3 үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн хэмжээ болон ДНБ-ийн

хоорондын хамаарлын төвшинг шинжилж үйлдвэрлэлийн бүтцийн хөгжил нь эдийн засгийн хөгжилтэй нийцэж байгаа эсэхийг тодрууллаа. Мөн Жарууд хошууны үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлт дэх эдийн засгийн үр нөлөөг тооцов. Үүний үндсэнд В.Петтигийн санал болгосон Петти-Кларк теоремийн дагуу үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлтийн эдийн засгийн үр нөлөөг нарийвчлан судалж, эдийн засгийн хөгжлийн явц дахь бүтцийн оновчтой бус асуудлыг шийдвэрлэх арга замыг дэвшүүлсэн болно. Шинжилгээг дараах дарааллаар гүйцэтгэв.

Нэг: Стандарт өгөгдлийн цуваа болон харьцангуй өгөгдлийн цувааг байгуулна. Шинжилгээ хийх системийн үр дүнг стандарт өгөгдлийн цуваагаар авах ба уг загварт хугацааны өөр өөр үе дэх ДНБ-ний утга байна. Системийн үр дүнд нөлөөлөгч бүрэлдэхүүн хэсгүүдийг харьцангуй өгөгдлийн цуваагаар авах ба уг загварт анхдагч, хоёрдогч, гуравдагч үйлдвэрлэл болно. Стандарт өгөгдлийн цувааг ерөнхийд нь X_0 , цувааны эхний үед харгалзах утгыг X_1 гэвэл стандарт өгөгдлийн цувааг тодорхойлох тэгшитгэл дараах байдалтай байна:

$$X_0 = \{X_0(1) + X_0(2) + \dots + X_0(n)\} \quad (1)$$

Харьцангуй өгөгдлийн цувааг ерөнхийд нь $X_i (i = 1, 2 \dots n)$ -ээр илэрхийлбэл харьцангуй

өгөгдлийн цувааг тодорхойлох тэгшитгэл дараах байдлаар илэрхийлэгдэнэ:

$$X_i = \{X_i(1) + X_i(2) + \dots + X_i(n)\}, i = 1, 2 \dots n \quad (2)$$

Хоёр: Анхдагч утгын аргаар хувьсагчийн утгыг тэгшитгэнэ. Анхдагч утгын арга нь хугацааны цувааны утга бүрийг эхний утгад хувааж, бүх

утгыг анхны утгаар тэгшитгэнэ. Дараах тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ.

$$X_0'(k) = X_0(k)/X_0(1); X_i'(k) = X_i(k)/X_i(1) \quad (3)$$

Үүнд, $i = 1, 2 \dots m ; k = 1, 2 \dots n$.

Гурав: Зөрүү утгаар хугацааны цуваа байгуулна. Энэ нь хамаарлын коэффициентыг

тооцоолоход илүү хялбар болгоно. Дараах тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ:

$$\Delta_i(k) = |X_i(k) - X_0(k)| \quad (4)$$

Үүнд, $i = 1, 2 \dots m ; k = 1, 2 \dots n$.

Дөрөв: Хамгийн их болон хамгийн баг утгыг тооцно. Хамгийн их, бага утга нь хамаарлын

коэффициент тооцоход ашиглагдана. Дараах тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ:

$$\Delta_{max} = \max \max |X_i(k) - X_0(k)| \quad (5)$$

Үүнд, $i = 1, 2 \dots m ; k = 1, 2 \dots n$.

$$\Delta_{min} = \min \min |X_i(k) - X_0(k)| \quad (6)$$

Тав: Саарал хамаарлын коэффициентыг тооцно.

$$\zeta_i(k) = \frac{\Delta_{min} + \rho * \Delta_{max}}{\Delta_i(k) + \rho * \Delta_{max}} \quad (7)$$

Үүнд, ρ -Distinguish coefficient, $\rho \in [0, 1]$ утга авна. Энд $\rho = 0.5$ болно.

Зургаа: Хамаарлын үр дүнг тооцоолж эрэмбэлнэ. Хамаарлын их, бага утга нь стандарт болон харьцангуй хугацааны цувааны хамаарлын төвшинг тодорхойлно. Хамаарал /1/-

д ойртох тусам хүчин зүйлийн хоорондын хамаарлын төвшин өндөр байна. Дараах тэгшитгэлээр тооцно.

$$r_i = \frac{1}{n} \sum_{k=1}^n \zeta_i(k) \quad (8)$$

Үүнд, $i = 1, 2 \dots m$.

Хугацааны цувааны өөр өөр үеүдэд r_i -ын утгыг тооцоолсны дараа үе шат бүрийн үндсэн 3 үйлдвэрлэлийн болон ДНБ-ний хоорондын

хамаарлын төвшинг тодорхойлно. Шалгуур үзүүлэлтийг үнэлгээний 3 зэрэглэлд ангилсан. А төрөл нь хамаарал өндөр байгааг илэрхийлэх

ба $[0.8,1]$ интервалд, В төрөл нь хамаарал дунд зэрэг байгааг илэрхийлэх ба $[0.7,0.8]$ интервалд, С төрөл нь хамаарал сул байгааг илэрхийлэх ба $[0,0.7]$ интервалд тус тус оршино. Тооцож гаргасан хамаарлын төвшинд

1989-2018 оны саарал хамаарлын шинжилгээний үр дүн

1989-2018 оны хооронд 30 жилийн хөгжлийн нөхцөл байдлаас харвал, үндсэн 3 үйлдвэрлэл болон ерөнхий эдийн засгийн хөгжлийн хамаарлын төвшний өөрчлөлт “1,2,3” хэлбэрээс “3,2,1”-д, дараа нь “1,3,2”-д шилжсэн хөгжлийн хандлагатай байна.

Нэгдүгээр үе шат (1989-1998 он)-д $r_1 > r_2 > r_3$ буюу эдийн засгийн хөгжил болон анхдагч үйлдвэрлэлийн хамаарлын төвшин $>$ эдийн засгийн хөгжил болон хоёрдогч үйлдвэрлэлийн хамаарлын төвшин $>$ эдийн засгийн хөгжил болон гуравдагч үйлдвэрлэлийн хамаарлын төвшин гэсэн эрэмбэ дараалалтай байна. Хамаарлын төвшин хамгийн өндөр байгаа нь $r_1=0.7374$ буюу дунд зэргийн хамааралтай байгаа ба анхдагч үйлдвэрлэлийн хөгжил нь эдийн засгийн ерөнхий хөгжлийг түргэтгэхэд хамгийн их хувь нэмэр оруулсан ба энэ үеийн хөгжлийн үндсэн чиглэл нь анхдагч үйлдвэрлэл байв. Хамаарлын төвшингээр хоёрдугаарт байгаа нь $r_2=0.7110$ буюу дунд зэргийн хамааралтай байгаа ба хоёрдогч үйлдвэрлэлийн хөгжил дөнгөж эхэн үедээ, эдийн засгийн хөгжил анхдагч үйлдвэрлэлээс харьцангуй удаан байсан. Хамаарлын төвшингээр гуравдугаарт байгаа нь $r_3=0.6366$ буюу хамаарлын төвшин бага байгаа ба энэ үе шатанд гуравдагч үйлдвэрлэлийн хөгжил нь эрэл хайгуулын үедээ байсан тул эдийн засгийн хөгжилд үзүүлэх хувь нэмэр харьцангуй бага байв. Энэ үе шатны хөгжлийн ерөнхий хандлагаас харвал, эдийн засгийн хөгжилд үзүүлэх үндсэн 3 үйлдвэрлэлийн хамаарлын төвшин бага байгаа ба энэ үе шатанд гуравдагч үйлдвэрлэлийн хөгжил нь эрэл хайгуулын үедээ байсан тул эдийн догч үйлдвэрлэлийн хөгжилд гар урлалын үйлдвэрлэл тэргүүлэх байр эзэлсэн сонгодог аж үйлдвэржүүлэлтийн эхэн үеийн хөгжлийн загвартай байна.

Хоёрдугаар үе шат (1999-2008 он)-д $r_3 > r_2 > r_1$ буюу эдийн засгийн хөгжил болон гуравдагч үйлдвэрлэлийн хамаарлын төвшин $>$ эдийн засгийн хөгжил болон хоёрдогч үйлдвэрлэлийн хамаарлын төвшин $>$ эдийн засгийн хөгжил болон анхдагч үйлдвэрлэлийн хамаарлын төвшин гэсэн эрэмбэ дараалалтай байна. Хамаарлын төвшин хамгийн өндөр нь $r_3=0.7406$

тулгуурлан хугацааны аль үе шатанд үндсэн 3 үйлдвэрлэлийн аль нь эдийн засгийн хөгжлийг хамгийн ихээр түргэтгэж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байгааг дүгнэнэ.

буюу дунд зэргийн хамааралтай, гуравдагч үйлдвэрлэл нь эдийн засгийн хөгжилд хамгийн их хувь нэмэр оруулах салбар болж хөгжлийн төвшин нь өмнөх үеэс мэдэгдэхүйц сайжирсан байна. Энэ үе шатанд гуравдагч үйлдвэрлэлийн аялал жуулчлал, зам тээвэр, жижиглэн худалдаа, байр, нийтийн хоолны үйлдвэрлэлийн салбарууд бүгд харилцан адилгүй хөгжсөн байна. Хамаарлын төвшин хоёрдугаарт $r_2=0.5286$ буюу сул хамаарлын төвшин бүхий хоёрдогч үйлдвэрлэлийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх хувь нэмэр мөн л 2 дугаарт байна. Гэвч өмнөх үеийн хөгжлийн ерөнхий төлөв байдалтай харьцуулбал эдийн засгийн хөгжлийг түргэтгэх нөлөөлөл нь тогтвортой бус байна. Хүнд үйлдвэрлэл, барилгын салбарын хөгжил нь хоёрдогч үйлдвэрлэлийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч байсан байна. Хамаарлын төвшин гуравдугаарт $r_1=0.4532 < 0.5$ буюу хамаарал багатай, тогтвортой бус байгаа нь эдийн засгийн хөгжилд нөлөөлөх анхдагч үйлдвэрлэлийн нөхцөл тааламжтай бус байгааг илтгэж байна. Ерөнхийлөн авч үзвэл, үндсэн 3 үйлдвэрлэлийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх хувь нэмэр “3,2,1” хэлбэртэй байгаа ба үйлдвэрлэлийн бүтцийн хөгжил “Петти-Кларк теорем”-той нийцэж, үйлдвэрлэлийн хөгжил нь зохистой, эдийн засгийн хөгжлийн зүй тогтлын дагуу явагдаж байна. Гуравдугаар үе шат (2009-2018 он)-д $r_1 > r_3 > r_2$ буюу эдийн засгийн хөгжил болон анхдагч үйлдвэрлэлийн хамаарлын төвшин $>$ эдийн засгийн хөгжил болон гуравдагч үйлдвэрлэлийн хамаарлын төвшин $>$ эдийн засгийн хөгжил болон хоёрдогч үйлдвэрлэлийн хамаарлын төвшин гэсэн эрэмбэ дараалалтай байна. $r_1=0.6764$ буюу хамааралтай багатай байгаа анхдагч үйлдвэрлэл дахин эдийн засгийн хөгжилд үзүүлэх хувь нэмрээр хамгийн өндөр үйлдвэрлэл болсон байна. $r_3=0.6658$ буюу хамаарлын төвшин багатай байгаа гуравдагч үйлдвэрлэлийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн хэмжээ өмнөх үеэс мэдэгдэхүйц буурсан байна. $r_2=0.53773$ буюу бага хамааралтай байгаа хоёрдогч үйлдвэрлэлийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх хувь нэмэр харьцангуй бага байгаа хэдий ч өмнөх үеэс ялимгүй өсжээ. Энэ үе шатыг ерөнхийд нь дүгнэвэл, үндсэн 3 үйлдвэрлэлийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх хувь нэмэр “1,3,2”

хэлбэрт шилжиж “**Т**хэлбэр” бүхий үйлдвэрлэлийн бүтэцтэй болсон нь үйлдвэрлэлийн бүтцийн хөгжил оновчтой бус,

бүтцийн загвар нь уялдаа муу, оновчтой болгох шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт

1. Жарууд хошууны аж үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлт нь ерөнхийдөө эдийн засгийн төвшний өсөлтийг түргэтгэж, эдийн засгийн түргэн хөгжлийг бий болгосон байна. Хоёр үе шатанд хийсэн эмпирик судалгааны үр дүнгээс үзэхэд Жарууд хошууны үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлтийн эдийн засгийн хөгжил урвуу U хэлбэрийн муруйгаар илэрхийлэгдэж байна. Өвөр Монголын 33 малжих хошууны нэг болохын хувьд МАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх байгаль, газар зүйн давуу талтай. Гэвч нэгдүгээр үе шат (1949-1988)-нд МАА-н үйлдвэрлэлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл зөвхөн улс байгуулагдсаны эхэн үед бага зэрэг тогтвортой, түүнээс хойш аажим суларсан байна.
2. Нэгдүгээр үе шатны сүүлчээр газар тариалангийн үйлдвэрлэлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл хамгийн их болсон ба үйлдвэрлэлийн бүтцийн хөгжил нь оновчтой бус байсан байна. Хоёрдугаар үе шат (1989-2009)-д, үндсэн 3 үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн бүтэц эдийн засгийн хөгжилтэй хэрхэн хамааралтай байгааг судалсан шинжилгээнээс харвал 3 үндсэн үйлдвэрлэл болон ДНБ-ийн хоорондын хамаарлын төвшин “1,2,3” хэлбэрээс “3,2,1” хэлбэрт, дараа нь “1,3,2” хэлбэрт шилжсэн хөгжлийн чиг хандлагатай байна. Өмнөх үе шатны хөгжил нь үйлдвэрлэлийн бүтцийн зүй зохистой хөгжлийн хандлагатай байгаа ба дараах үе шат нь “1,3,2” байгаа нь "Петти-Кларкын теорем"-ыг зөрчиж, үйлдвэрлэлийн бүтцийн хөгжил оновчтой бус, сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- [1] Ган Чуньхуй, Жэн Рүогу, Юй Дианфан. Хятадын үйлдвэрийн бүтцийн өөрчлөлтийн эдийн засгийн өсөлт, тогтворгүй байдалд үзүүлэх нөлөө [J]. Эдийн засгийн судалгаа, 2011,46 (5).
- [2] Ли Хуимин, Ван Шумэй, Дун Меньяо. Ляонингийн аж үйлдвэрийн бүтэц ба эдийн засгийн өсөлтийн хамаарлын шинжилгээ [J]. Эдийн засгийн тусгай бүс, 2015 (11): 70-72.
- [3] Ли Сяоли. Далиан хотын аж үйлдвэрийн бүтэц болон эдийн засгийн өсөлтийн саарал хамаарлын шинжилгээ [J]. Далианы зам харилцааны их сургуулийн сэтгүүл, 2014,35 (S1): 187-189.
- [4] ӨМӨЗО-ын Статистикийн газар. Өвөр Монголын статистикийн эмхтгэл [J]. Бээжин: Хятадын статистикийн хэвлэлийн хороо, 2020 он.
- [5] Уильям Петти, Ма Ян (орчуулсан), Улс төрийн арифметик [M]. Бээжин: Хятадын нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо, 2010 он.
- [6] Шю Жинжун, Лю Хэнг. Хятадын эдийн засгийн мөчлөгийн хэлбэлзлийн аж үйлдвэрийн бүтцийн онцлог [J]. Юннань үндэстний их сургуулийн сэтгүүл: Философи ба нийгмийн шинжлэх ухааны хэвлэл, 2005 (3) .31-37.
- [7] Шиун Иньвү, Вү Гуоухуа. Үйлдвэрийн бүтцийг оновчтой болгох эдийн засгийн оновчтой өсөлт [J]. Эдийн засгийн судалгаа, 1990 (3).
- [8] Зуо Цихин. Вүхан хотын аж үйлдвэрийн бүтцийн оновчлол ба эдийн засгийн өсөлтийн эмпирик судалгаа [J]. Эдийн засгийн судалгааны хөтөч, 2012 (8): 69-71.
- [9] Жарууд хошууны МАА-н газар. Жарууд хошууны мал аж ахуйн ойллого[M]. Бээжин: Орон нутгийн ойллого хэвлэлийн газар, 1991 он.
- [10] Жарууд хошууны МАА-н газар. Жарууд хошууны мал аж ахуйн ойллого[M]. Бээжин: Орон нутгийн ойллого хэвлэлийн газар, 1997 он.
- [11] Жарууд хошууны ойллого эмхэтгэх хороо. Жарууд хошууны ойллого[M]. Бээжин: Орон нутгийн ойллого хэвлэлийн хороо, 2001.
- [12] Жарууд хошууны ойллого эмхэтгэх хороо. Жарууд хошууны ойллого[M]. Хөлөнбуйр: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 2010.
- [13] Жарууд хошууны архивын газар. Жарууд эмхэтгэл[M]. Бээжин: Хятадын уран зохиол, түүхийн хэвлэлийн хороо, 2010-2020.

Analysis on the industrial structure change of animal husbandry banner in Inner Mongolia, China (taking zaruud as an example)

Burenjargal Tangudai¹, Horiwa Bayujin^{1*}, Badarch Sundui²

¹ School of Ethnology and Sociology, Inner Mongolia University, University West ST 235, Khuh-khot, Inner Mongolia, P.R.C

² School of Economics and Business, Mongolian University of Life Sciences, Zaisan 17024, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: 22113006@mail.imu.edu.cn

Received: 01.10.2021

Revised: 08.11.2021

Accepted: 31.12.2021

Abstract

This paper uses the grey relational analysis on the relationship between industrial structure and economic growth in Zaruud Banner. Zaruud Banner located in the pastoral area of northern China, which is known as marginal, ethnic, ecologically fragile and less-developed area. The results of the study illustrate the periodical changes in its industrial structure change and summarize its overall development situation. On the basis of the empirical research, Zaruud Banner should adjust the industrial structure and develop a modern industrial system; improve the industrial efficiency; strengthen the construction of industrial zones; pay attention to the development of the industrial chain and improve the product quality.

Keywords: pastoral banner area; industrial structure change; zaruud banner